

Нэг. “АСГАТ” НИЙСЛЭЛИЙН ӨМЧИТ УЛСЫН ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ТҮҮХЧИЛСЭН ЛАВЛАХ

1965 онд Улаанбаатар хотын хороодод шинэчилсэн зохион байгуулалт хийж 5 районыг байгуулж райодын АДХГЗ-нд Боловсролын хэлтсийг шинээр байгуулж хотын АДХГЗ-ны дэргэдэх Гэгээрлийн хэлтсийн харъяалалд байсан сургууль, цэцэрлэгийн нягтлангуудыг районы Боловсролын хэлтэст шилжүүлснээр Октябрийн районы боловсролын хэлтэс 8 нягтлантай, сантехникийн ажил хариуцсан 1 механик, цахилгаан шугам сүлжээ хариуцсан дунд мэргэжлийн монтёр 1-тэй ажилласан юм.

Нийслэл хотын эрэлт хэрэгцээгээр сургууль, цэцэрлэг нэмэж байгуулах шаардлага, хороолол баригдах ерөнхий төлөвлөгөөгөөр хотын 4 районд цэцэрлэг, сургуулийн тоо нэмэгдэж райодын боловсролын хэлтсүүд ЕБС, цэцэрлэгийн аж ахуй, санхүүг өдөр тутам удирдахад хүндрэлтэй болсноор 1970-аад оны эхээр байгуулагдсан санхүү аж ахуйн тасгийг 1980 онд мөн хэлтсийнхээ харъяанд сургууль цэцэрлэгийн нэгдсэн аж ахуйн төв болгох шийдвэрийг Улаанбаатар хотын АДХГЗ гаргаж уул төвийг район бүрт бие даасан байртай агуулах складтай, цэцэрлэг сургуулийг өдөр бүр хэрэглэгдэх хүнсний бүтээгдэхүүнээр хангаж, анхан шатны тооцоо тоо бүртгэлийг гардан хариуцдаг төв байхаар зохион байгуулсан.

Энэ шийдвэрийн дагуу Октябрийн районы АДХГЗ-ны Ардын боловсролын хэлтсийн харъяанд 34 ажиллагсадтай. үүнд: Дарга-1, ахлах ня-бо-1, тооцооны ня-бо-11, аж ахуйн нярав- 6, түгээгч ачигч, механик, слесарь, морь тэрэгчин, жолооч, үйлчлэгч, харуул, манаа, бичээч зэрэг үйлчилгээний 16 ажилтан ажилчидтай байгуулж районы 20 сургууль, / 73, 46, 28, 40, 13, 47, 22, 70, 51, 20, 38, 19, 9, 66, 12, 42, 65, 62, 67, 76 / , 15 цэцэрлэг / 34, 47, 55. 90, 79, 81, 23, 26, 11, 87, 86, 57, 66, 78, 84 / -дэд үйлчлэхээр зохион байгуулагдсан.

Ийм зохион байгуулалтанд орсноор сургууль, цэцэрлэгт ажиллаж байсан ня-бо, тэрэгчин, слесарь зэрэг албан тушаалын 42 орон тоог цомхотгосон. Тэр үеийн ханшаар жилд 304-348 мянган төгрөгийн хэмнэлттэй, зөвхөн 1980-1984 онд цалингаа хэмнэж байсан.

1983-1992 онд 3,4, 1-р хороолол дуусч олон зуун хөдөлмөрчид суурьшсанаар хороолол дагасан сургууль, цэцэрлэгүүд ашиглалтанд орж аж ахуйн төвийн үйлчлэх хүрээ өргөжиж эрэлт шаардлага ихсэв. Үүнээс шалтгаалж сантехникийн засвар үйлчилгээний төвлөрсөн хэсэг ажиллуулж, санхүүгийн анхан шатны бүртгэл тооцоог шуурхай, үнэн зөв явуулах орчин үеийн цахилгаан, машин техниктэй болж өргөжсөн. 1980 онд анх байгуулагдаж байх үед 683 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэйгээр үйл ажиллагаагаа эхлүүлж байсан бол 1991 онд 3 миллиард 412 сая төгрөг болтлоо өссөн юм.

Өмч хувьчлах, бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийх, төсвийн байгууллагын бие даасан байдлыг хангах, райодын ачааллыг тэнцүүлэх зорилгоор хотын томоохон 2 районыг

хувааж Сүхбаатар, Чингэлтэй, Баянгол, Сонгинохайрхан болгож район гэдэг нэрийг дүүрэг болгон АДХГЗ-аас Дүүргийн Засаг даргын Тамгын газар болгон өөрчилж, захиргааны орон тоо, Хэлтэс тасгуудыг хөдөлмөрчдөд ойртуулах, ажлын давхардах чирэгдийг арилгах зорилгоор Ардын боловсролын хэлтсүүдийг татан буулгаж сургууль, цэцэрлэгүүдийг дүүрэгт харъяалуулж аж ахуйн төвөөс үйлчлэх хүрээг тэнцүүлж Баянгол, Сонгино хайрхан 2 дүүрэгт тус бүрд нь 20-иод сургууль, 30-аад цэцэрлэг оногдсон. Баянгол дүүргийн аж ахуйн төвийг Асгат, Сонгино хайрхан дүүргийн төвийг Тахилт гэдэг нэртэйгээр ББХК болгон 1992 оны 10-р сарын 01-нээс зохион байгууллаа.

Сургууль цэцэрлэгийн нэгдсэн аж ахуйн төвийг байгуулсан 1980 оноос хойш тус төв, УУГ-ыг Х.Баатархүү 1980 оны 3-р сараас 1981 оны 8-р сарын 01, Г.Бадамдорж 1981 оны 8-р сарын 1-нээс 1982 оны 8-р сарын 25, Бямбаа 1982 оны 8-р сарын 25-наас 1985 оны 3-р сар, Д.Гэндэншарав 1985 оны 3-р сараас 1992 оны 6-р сар, Р.Дондов 1992 оны 10-р сарын 1-нээс 1997 оны 04-р сараас Балжиннямын Ёндонсүрэн, 2011 оны 04-р сарын 22-оос 2013 оны 09-р сарын 06-аас 2013 оны 09 сарын 06-ны өдрийг хүртэл Шоовдорын Гантөмөр, 2013 оны 09 сарын 06-ны өдрөөс Дамиран овогтой Майцэцэг нар томилогдон өнөөг хүртэл ажиллаж байна.

Тус Асгат НӨҮГ-нь 2014 оны байдлаар 21 ажилтан ажилчидтай. Аж ахуйн материаллаг баазын хувьд бэхжиж, 794 толгой малтай, 16 машины дулаан гаражыг түрээслүүлэн ажиллуулж байна. Тус байгууллага нь жилдээ дунджаар 70 орчим нэр төрлийн хоол хүнсний материал болон аж ахуйн бараа материал татан авч жилдээ 2,5 тэрбум орчим төгрөгийн борлуулалт хийж, Баянгол дүүргийн цэцэрлэгүүдийн гал тогооны тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг хариуцан хэвийн ажиллагааг бүрэн хангаж ажилладаг байгууллага юм.

Тус байгууллагын тоног төхөөрөмжийн механик нь Баянгол дүүргийн сургууль, цэцэрлэгийн эзэмшлийн актлах шаардлагатай сургалтын болон гал тогооны тоног төхөөрөмжүүдийг газар дээр нь үзэж эвдрэл, гэмтлийг тогтоож, актлуулах саналаа НӨХГ-т албан тоотоор явуулах ажлыг 2006 оноос хариуцан ажиллаж байна.

Асгат НӨҮГ-ын Нийслэл, дүүрэг хөгжүүлэх эдийн засгийн зорилтыг хэрэгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг үнэлж 1999 онд Баянгол дүүргийн "ИТХТ-ийн өргөмжлөл", 2002 онд Нийслэлийн Өмчийн харилцааны газраас харъяа байгууллагуудын дунд зарласан Тэргүүний Өмчит УУГ шалгаруулах болзолт уралдаанд 2-р байр эзэлж НӨХГ-ын "Хүндэт итгэмжлэл", 2002 онд Баянгол дүүргийн Засаг даргын өргөмжлөл, 2001-2004 онуудад Баянгол дүүргийн "Хүндэт өргөмжлөл", 2007 онд Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын "Тэргүүний хамт олон" өргөмжлөл, 2007 оны ажлаа дүгнүүлж манай байгууллагын захирал Нийслэлийн өмчийн харилцааны газрын "Шилдэг менежер" өргөмжлөлөөр мөн 4 хүн дүүргийн Хөдөлмөрийн аваргаар шалгарч, дүүргийн хүндэт дэвтэрт бичигдсэн, 2013 онд ерөнхий нягтлан бодогч

Д.Цэцэгмаа “Алтан гадас” одонгоор, ахлах нярав Д.Бадамсамбуу “Хөдөлмөрийн хүндэт медаль”-аар, үйлчлэгч Л.Хашгэрэл Баянгол дүүргийн Засаг даргын нэрэмжит шагналаар шагнагдсан зэрэг амжилт бүтээл арвинтай хамт олон юм.

Хоёр. ХӨМРӨГИЙН БАРИМТЫН ТҮҮХ

Тус байгууллагын 1980 - 2003 оны архивын баримтанд 2004.06.30 - 2004.07.21-ний хооронд Нийслэлийн архивын албаны архивч Л.Баттогтох эрдэм шинжилгээ боловсруулалтын ажлыг хийхдээ байнга хадгалах 1980-2003 оны 49 хн, түр хадгалах 1994 -2003 оны 226 хн, 70 жил хадгалах 1979-2003 оны 26 хадгаламжийн нэгжийг бүртгэлд оруулж, дугаар өгсөн.

Эрдэм шинжилгээ техник боловсруулалтын ажлыг хийхдээ: Эрдэм шинжилгээ техник боловсруулалт хийх журам, Архивын ажлын үндсэн зааврыг удирдлага болгон дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн юм. Үүнд:

- Баримт бичгийг он, зохион байгуулалтын ач холбогдлоор нь төрөлжүүлэн ангилсан
- Байнга, түр, 70 жил хадгалахаар цэгцэлсэн
- Байнга хадгалах хадгаламжийн нэгжийн хуудас дугаарлан үдэж хавтаслах, баталгаа бичих, нүүр тэмдэг дарах, нуруу цаас наах, хадгаламжийн нэгжид дугаар өгөх зэрэг ажлуудыг хийсэн.

Цаашид үйл ажиллагаагаа явуулах тул түр хадгалах 1996-2003 оны 226 хадгаламжийн нэгжийг байгууллага дээр цэгцэлж архивын өрөөнд байрлуулж оны зааглагчийг бичиж хүлээлгэн өгсөн.

Тус байгууллагын байнга хадгалах баримт нь даргын болон захирлын тушаал, хурлын тэмдэглэл, үндсэн хөрөнгийн тооллогын бүртгэл, нягтлан бодох бүртгэл тайлан тэнцэл зэрэг баримтаас бүрдэж байгаа .

Байнга, түр, 70 жил хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл үйлдэж жагсаалтыг НАА-ны дэргэдэх БНШАЗК-ын 2004 оны 11-р сарын 22-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан болно. Мөн Хотын боловсролын газрын харъяа байгууллагуудын баримтыг төвлөрүүлэх зорилгоор Октябрийн районы НААТөвийн даргын тушаал 1980-1990 оны 13 ХН буюу 1545 хуудас, Октябрийн районы сургууль, цэцэрлэгүүдийн цалингийн карт 1978-1988 оны 111 ХН буюу 5096 хуудас, нийт 124 хадгаламжийн нэгжийн жагсаалт гарган 2003 оны 3-р сарын 6-ны өдөр Нийслэлийн Боловсролын удирдах газрын архивын ажилтан Т.Алтанцэцэгт хүлээлгэж өгсөн болно. Байрын хүрэлцээ муутайн улмаас дүүргийн харъяа 87-р цэцэрлэгийн подвалд түр хадгалж байсан Октябрийн районы СЦНААТ-ийн 1980-1984 оны байнга болон түр хадгалах хадгаламжийн нэгжийн баримтууд 1986 оны усны үерээр урсаж үгүй болсон байна.

Архивын ажлын үндсэн зааврыг удирдлага болгон 2004 - 2006 оны баримтыг байнга, түр, 70 жил хадгалахаар цэгцэлсэн. Мөн байнга хадгалах хадгаламжийн нэгжийн хуудсыг дугаарлан үдэж хавтаслах, хадгаламжийн нэгжид дугаар өгөх зэрэг ажлуудыг хийлээ.

2004-2006 оны байнга хадгалах 50-67 дугаар бүхий 18 ХН, 70 жил хадгалах 27-31 дугаар бүхий 5 ХН, түр хадгалах 227-325 дугаар бүхий 99 хадгаламжийн нэгжийг бүртгэлд оруулж дугаарласан. Байгууллагын дэргэдэх БНШК-ыг Захирлын 2007 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 78 тоот тушаалаар Комиссын дарга менежер Ц.Амарсанаа, нарийн бичгийн дарга архивын эрхлэгч Х.Ичинхорлоо, гишүүн тооцооны нягтлан бодогч Б.Алтанзул нарын 3 хүний бүрэлдэхүүнтэй томилон ажиллуулж байна Захирлын 2007 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 79 тоот тушаалаар тооллогын комисс томилон 2004-2006 оны байнга хадгалах 18 ХН, түр хадгалах 325 ХН, 70 жил хадгалах 5 ХН-ийг тус тус бэлнээр тоолсон ба 2003 онд Нийслэлийн архивын албаны БНШАЗК-ын хурлаар батлагдсан байнга хадгалах 1980-2003 оны 49 ХН, 70 жил хадгалах 1979-2003 оны 26 ХН-ийг тооллогын бүртгэлд оруулж нийт 423 ХН тооллогонд хамруулан НАА-д баримтын тооллогын хуудас, баримтын тооллогын акт №1-ийг илтгэх хуудсын хамт хүлээлгэж өгсөн..

БНШК-ын 2007 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хурлаар тус байгууллагын архивт хадгалагдаж буй 2004-2006 оны байнга, түр, 70 жил хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл танилцуулах мөн архивын баримтанд тооллого хийсэн дүн зэргийг хэлэлцүүлж батлуулсан болно.

Тус байгууллагын архивын баримтанд Нийслэлийн Засаг даргын 2007 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 414 дүгээр захирамж, Үндэсний Архивын газрын Төрийн ба төрийн бус байгууллагын архивын баримтанд тооллого явуулах ажлын удирдамжийг үндэслэн Захирлын 2007 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 79 тоот тушаалаар томилогдсон Ахлах нягтлан бодогч Д.Цэцэгмаа, Архивын эрхлэгч Х.Ичинхорлоо, Инженер Л.Очирбат, Нярав С.Нянтайсүрэн нарын бүрэлдэхүүнтэй тооллогын комисс батлагдсан данс бүртгэлтэй байнга хадгалах 49 ХН буюу 5298 хуудас, түр хадгалах 252 ХН буюу 52210 хуудас, батлагдаагүй данс бүртгэлтэй байнга хадгалах 18 ХН буюу 2554 хуудас, түр хадгалах 104 ХН буюу 20143 хуудас , нийт 423 ХН буюу 80205 хуудас баримтыг тооллогод хамруулсан болно.

Мөн Нийслэлийн Засаг даргын 2011 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 250 дугаарын захирамжыг үндэслэн “Асгат” НӨҮГазрын захирлын 2011 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 32 тоот тушаалаар томилогдсон тооллогын комисс нийт 414 /Дөрвөн зуун арван дөрөв/-н хадгаламжийн нэгжийг бэлэн тоолов.

Тайлбар: 2003 онд Нийслэлийн Архивын албанд шилжүүлсэн Байнга хадгалах 49ХН, 70 жил хадгалах 26 ХН буюу нийт 75ХН-ийн 85392 хуудсыг нэгдсэн бүртгэлд оруулж тоолсон.

Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Архивын газрын албан бичгийн дагуу “Асгат” НӨҮГ-ын захирлын 2014 оны 02 сарын 06-ны өдрийн А/10 дугаарын тушаалаар томилогдсон ажлын хэсэг НАГ-аас баталсан хуваарийн дагуу “Асгат” НӨҮГ-ын архивын бичиг баримтыг нөхөн бүрдүүлэх үйл ажиллагааны хүрээнд НАГ-ын арга зүйч, зааварлагч Жүгдэрнамжилын заавар, зөвлөмжийн дагуу 2014 оны 1-р улиралд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн болно. Үүнд:

Байгууллагын захирал, ерөнхий нягтлан бодогчийн зөвшөөрснөөр 2000-2009 онуудын НББ-ийн баримтыг задлан жилийн эцсийн санхүүгийн тайлан, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан, байгууллагын үйл ажиллагаанд хийсэн санхүүгийн болон аудитын шалгалтын материал, үндсэн хөрөнгийн тооллогын бүртгэлийг, 2008 оноос хойшхи явуулсан, ирсэн албан бичгийн үндсэн үйл ажиллагааны холбогдолтойг байнга хадгалахаар, цалингийн хүснэгт, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тооцооны хуудсыг 70 жил хадгалахаар гэх мэт баримт бичгийг он, зохион байгуулалтын ач холбогдлоор нь төрөлжүүлэн ангилсан

Архивын ажлын үндсэн зааврыг удирдлага болгон 2000 - 2013 оны баримтыг байнга, түр, 70 жил хадгалахаар цэгцлэн, ач холбогдлоороо шаардлагагүй болсон баримтуудыг бүртгэн устгах хэргийн нэрийн жагсаалт үйлдсэн болно. Мөн дээрхи хадгаламжийн нэгжүүдийн хуудсыг дугаарлан үдэж хавтаслах, хадгаламжийн нэгжид дугаар өгөх зэрэг ажлуудыг хийлээ.

Байгууллагын дэргэдэх ББНШК-ыг Захирлын 2014 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн тушаалаар Комиссын дарга менежер Ц.Жамсран, нарийн бичгийн дарга архивын эрхлэгч Д.Ган-Очир, гишүүн тооцооны нягтлан бодогч Б.Алтанзул нарын 3 хүний бүрэлдэхүүнтэй томилон ажиллуулж байна. Захирлын тушаалаар томилогдсон ажлын хэсэг /тооллогын комисс/ 2000-2009 оны байнга хадгалах 52 ХН-ийн 1246 хуудас, 2010-2013 оны байнга хадгалах 33 ХН-ийн 1035 хуудас, 2001-2013 оны түр хадгалах 360 ХН, 2000-2013 оны 70 жил хадгалах 42 ХН-ийн 1384 хуудсыг тус тус бэлнээр тоолсноос гадна 2003 онд Нийслэлийн архивын албаны ББНШАЗК-ын хурлаар батлагдсан, Нийслэлийн Архивын газар хадгалагдаж байгаа байнга хадгалах 1980- 2003 оны 49 ХН, 70 жил хадгалах 1979 – 2003 оны 26 ХН буюу 75 ХН-ийг тооллогын бүртгэлд оруулан тоолов. Мөн 2000-2009 оны, 2010-2013 оны байнга, 2000-2013 оны 70 жил, түр хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл 4, устгах хэргийн акт 1 зэргийг тооллогод хамруулан архивын баримтын мэдээг үндэслэн

баримтын тооллогын хуудас, баримтын тооллогын акт үйлдсэн болно. Тооллогын явцад элдэв зөрчил, дутагдал илрээгүй болно.

Өнөөгийн байдлаар байнга хадгалах 86 ХН, 70 жил хадгалах 42 ХН, түр хадгалах 360 ХН-г бүртгэн тоолоод байна.